



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 8/685

Арвайхээр

Газар ашиглалтын зориулалтад өөрчлөлт оруулах тухай


Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 3.4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн З.Түвшинжаргал (РЭ80060908)-ын гаргасан хүсэлтийн дагуу Арвайхээр сумын 5 дугаар баг Б.Ренчинпэлжээгийн гудамж 135 тоотод байрлах үйлчилгээний зориулалттай 487m^2 газрын зориулалтыг нийтийн орон сууц, Н.Өлзийбадрах (ИЮ87102511)-ын эзэмшил 13 дугаар баг Мэргэд 6 дугаар гудамж 600 тоотод байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 400m^2 газрын зориулалтыг нийтийн орон сууцны зориулалттай болгон тус тус өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011101291

D:My Doc. Zahiramj. Zasag darga